

Монгол, Солонгосын харилцаанд холбогдох хоёр шинэ бүтээлийн тухайд

Дашидаваагийн Мягмар

*ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Бүс нутаг, олон талт хамтын
ажиллагаа судлалын салбарын эрдэм шинжилгээний ажилтан, магистр
myagmar_d@mas.ac.mn*



2021 онд ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгээс “Монгол Улс, БНСУ-ын харилцаа: Баримт бичгийн эмхэтгэл 1990-2019”, “Монгол Улс, БНСУ-ын харилцаа: Он дарааллын товчоон 1990-2019” хэмээх ихэр хоёр бүтээлийг эрхлэн хэвлүүлсэн байна. Эдгээр бүтээлийг Монгол Улс, БНСУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 30 жил, ШУА байгуулагдсаны 60 жилийн ойд зориулан хэвлүүлжээ.

Монгол Улс, БНСУ-ын харилцаа, хамтын ажиллагаа эрчимтэй хөгжихийг дагалдан бодлого тодорхойлогчид, шийдвэр гаргачдаас эхлээд эрдэмтэн

судлаачид, дипломатчид, бизнес эрхлэгчид, оюутан залуус, энгийн иргэд хүртэлх бүх түвшинд хоёр улсын харилцааны тухайд байнга хэрэглэгдэх гарын авлага, лавлагааны чанартай нэгдмэл эх сурвалж тун чухлаар шаардагдах болоод байв. Мөн тус хүрээлэнгээс Монгол Улсын гадаад харилцааны анхдагч эх сурвалжуудад тулгуурлан он цагийн товчоон хийгээд баримт бичгийн эмхэтгэлүүдийг Монгол Улсын гадаад харилцаанд чухал байр суурь эзлэх орон тус бүрээр эрхлэн гаргах цуврал ажлыг хэрэгжүүлж байгаа нь энэ удаад Монгол, Солонгосын хооронд дипломат харилцаа тогтоосны хагас жарны ойтой давхацсан билээ. Тиймийн учир нэгдүгээрт, нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангах; хоёрдугаарт, хоёр орны дипломат харилцааны тэмдэглэлт ойг эрхэмлэх; гуравдугаарт, хүрээлэнгээс чухалчлан үзэж буй цуврал ажлыг урашлуулахыг чухалчлан Монгол Улсын Гадаад харилцааны төв архив зэрэг холбогдох



<https://creativecommons.org/licenses/by/4.0/>

<https://orcid.org/0000-0001-9678-8338>

төрийн байгууллагуудад хадгалагдаж буй албаны баримт бичгүүдэд тулгуурлан энэхүү хоёр бүтээлийг эрхлэн гаргасан байна.

“Монгол Улс, БНСУ-ын харилцаа: Баримт бичгийн эмхэтгэл 1990-2019” нь өмнөх үг, товчилсон үгийн жагсаалт, баримтын үндсэн агуулга, баримт бичгийн ангилал, хүний нэр болон нэр томьёоны хэлхээнээс бүрдэх нийт 506 хуудас бүхий 42.3 хэвлэлийн хуудас хэмжээтэй ба дурдсан хугацаанд хамаарах хоёр улсын улс төр, эдийн засаг, нийгэм, хөгжлийн хамтын ажиллагаанд холбогдох 203 баримт бичгийг багтаасан томоохон хэмжээний эмхэтгэл юм. Эмхэтгэлд багтсан баримтууд нь хоёр улсын төрийн тэргүүдийн харилцан айлчлалын үеэр гарсан хамтарсан мэдэгдэл; Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээр, хөтөлбөрүүд; хоёр улсын Ерөнхий сайд, парламентийн гишүүд, засгийн газрын гишүүд, нийслэл хотын удирдлага зэрэг албан тушаалтнуудын харилцан айлчлалын баримт бичгүүд; хоёр улсын харилцаанд холбогдох бусад албан бичиг, тушаал захирамжууд; зарим чухал ач холбогдол бүхий цаг үеийн мэдээ, засгийн газар хоорондын хамтарсан хуралдааны тэмдэглэлүүд; Монгол-Солонгосын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах хамтарсан судалгаа зэрэг баримт бичгийн төрөл зүйлээс бүрдэнэ.

“Монгол Улс, БНСУ-ын харилцаа:

Он дарааллын товчоон (1990-2019)” нь өмнөх үг, товчилсон үгийн жагсаалт, он дарааллын товчоон, нэрийн хэлхээнээс бүрдэх 235 хуудастай ба дурдсан хугацаан дахь хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны үйл явдлуудыг он цагийн дарааллаар жагсаажээ. Чингэхдээ Монгол, Солонгосын улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, боловсрол, байгаль орчин зэрэг олон салбарын харилцаа хамтын ажиллагааны үйл явдлуудыг гагцхүү албан ёсны баримт бичгүүдэд тэмдэглэгдсэн байдлыг баримтлан оруулсан байна. Уг товчооныг Монгол Улсын Гадаад харилцааны төв архив, Үндэсний төв архив, зарим яам тамгын газар, агентлагуудад хадгалагдаж буй баримт бичгүүдийг түшиглэн бүтээжээ.

Манай хүрээлэнгийн судлаачдын эрхлэн бэлтгэж хэвлүүлсэн “Монгол Улс, БНСУ-ын харилцаа: Баримт бичгийн эмхэтгэл”, “Монгол Улс, БНСУ-ын харилцаа: Он дарааллын товчоон” нь тус бүрдээ Монгол Улс, БНСУ-ын харилцааны түүхэнд холбогдох архивын баримтаар дагнасан, тулгуурласан анхны бүтээлүүд болж буй онцлогтой бөгөөд мэргэн уншигч Таны мэдлэгийг тэлж судалгаа, лавлагааны тань чухал хэрэглэгдэхүүн болно гэдэгт итгэж байна.